



Монголиан Файнэншл Партнерс ББСБ

**2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**



Агуулга

ТУЗ-ийн даргын мэндчилгээ

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл

ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тойм

Компанийн засаглал

Компанийн бүтэц, зохион байгуулалт

Санхүүгийн мэдээлэл

Сургалт хөгжил, соёлын арга хэмжээ

Компанийн онцлох үйл явдлууд



ТУЗ-ийн даргын мэндчилгээ

Л.Батхуяг /ТУЗ-ийн дарга/

Манай цахим хуудсанд зочлон саатаж буй эрхэм танд “Монголиан Файнэншл Партнерс ББСБ” ХХК-ийн хамт олны өмнөөс халуун мэндчилгээ дэвшүүлж байна.

Монгол Улсынхаа хөгжил, дэвшилд өөрсдийн хувь нэмрийг оруулах, банк бус санхүүгийн салбарын хөгжлийг шинэ түвшинд хүргэх эрхэм зорилгын хүрээнд бид үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш өдгөө 8 жилийн хугацаа өнгөрчээ.

Энэ хугацаанд бид компанийн засаглалын зөв зарчмыг баримтлан, байгууллагын бүхий л түвшинд хариуцлагатай, эрсдэлийн удирдлагад суурилсан, харилцан уялдаа холбоотой, чанартай, мэргэжлийн ёс зүйтэй үйл ажиллагааг эрхэмлэн ажиллаж ирлээ. Мөн харилцагчдынхаа эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг түргэн шуурхай, мэргэжлийн өндөр түвшинд хүргэж, та бүхний үргэлжийн хариуцлагатай түнш байхыг зорин ажиллаж байна.

Манай компани салбарын туршлагатай, чадварлаг хамт олныг бүрдүүлж чадсан бөгөөд банк бус санхүүгийн салбарын өрсөлдөөнт зах зээлд хамтын хүч, тогтвортой хөгжлийн бодлогын үндсэн дээр байр сууриа улам бэхжүүлэн, төлөвлөсөн зорилт, зорилгоо амжилттай хэрэгжүүлж байгаагаа онцлон гэмдэглэхэд таатай байна.

Энэхүү мэндчилгээгээр дамжуулан өнөөг хүртэл бидэнтэй хамтран ажиллаж ирсэн нийт харилцагч, түнш байгууллага, захиалагч та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлье. Цаашид бид үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн хөгжүүлж, хамтын хүчээр улс эх орныхоо хөгжилд бодит хувь нэмэр оруулсаар байна гэдэгт итгэл төгс байна.

Хүндэтгэсэн,
Л. Батхуяг



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Л.Сэлэнгэ /Гүйцэтгэх захирал/

“Монголиан Файнэншл Партнерс ББСБ” ХХК нь нийт харилцагч, хамтран ажиллагч та бүхэндээ 2025 оны үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байгаадаа таатай байна.

Сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн салбар тогтвортой өсөлт, хөгжлийг хадгалж буй энэ үед манай байгууллага банк, санхүүгийн салбарт арвин туршлагатай, мэргэжлийн чадварлаг баг хамт олныг бүрдүүлэн ажиллаж байна. Бид иргэд болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулахыг эрхэм зорилгоо болгон ажилладаг. Үүний зэрэгцээ харилцагч, үйлчлүүлэгч бүрд түргэн шуурхай, соёлч боловсон үйлчилгээг хүргэж, тэдний эрх ашиг, хэрэгцээ шаардлагыг нэн тэргүүнд тавин, харилцан итгэлцэлд суурилсан урт хугацааны хамтын ажиллагааг бий болгоход онцгойлон анхаарч байна.

Манай байгууллага үйл ажиллагаагаа эхлүүлсэн цагаас хойш Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагад тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол ханган ажиллаж ирсэн бөгөөд цаашид ч тогтвортой, хариуцлагатай, харилцагч төвтэй үйл ажиллагааг эрхэмлэн ажиллах болно.

Хүндэтгэсэн,
Л. Сэлэнгэ



ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн



Л.Батхуяг /ТУЗ-ийн дарга/

“Монголиан Файнэншл Партнерс ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд 2025 оноос хойш ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна.

Боловсрол:

2000-2003 Казакстаны эдийн засгийн их сургууль – Банкны эдийн засагч

2011-2013 БНХАУ-н Beijing Normal University – Магистр

Ажлын туршлага:

2003-2008 Анод банк – Дотоод хяналт

2009-2011 Хьюнда моторс Монгол ХХК – Санхүү, борлуулалт хариуцсан захирал

2011-2012 Хера констракшн – Бээжин дэх төлөөлөгч

2012-2014 Монкон групп ХХК – Гүйцэтгэх захирал

2015-2022 Монкон пропертис ХХК – Ерөнхий захирал

2022-2025 Монголиан Файнэншл Партнерс ББСБ ХХК – Гүйцэтгэх захирал

2025 оноос ТУЗ-ийн дарга



ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн



Г.Батбаяр /ТУЗ-ийн гишүүн/

Боловсрол:

2000-2004 Dokuz Eylul Uni – Civil Engineering

2007-2008 Istanbul teknik uni – Civil Engineering /Магистр/

2014-2015 СЭЗИС – Менежмент санхүү

Ажлын туршлага:

2008-2009 MCS холдинг ХХК – Төслийн менежер

2009-2012 Энержи ресурс ХХК – Барилга хариуцсан дэд захирал

2012-2013 Самсунг ХХК – Төслийн координатор

2013-2014 Хера констракшн ХХК – Барилга хариуцсан захирал

2014 оноос Монкон констракшн ХХК – Гүйцэтгэх захирал



Б.Баярчулуун /ТУЗ-ийн гишүүн/

Боловсрол:

1997-2001 ОХУ Эрхүү хотын их сургууль – Санхүүч эдийн засагч

Ажлын туршлага:

2003-2008 Анод банк – ББГ ахлах

2009-2010 Юнител – БХАГ-н менежер

2010 оноос Монкон констракшн ХХК – Үйл ажиллагаа хариуцсан захирал



ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн



Ш.Цэрэндаваа /ТУЗ-ийн хараат бус гишүүн/

Боловсрол:

1992-1995 СЭЗДС – Нягтлан бодох бүртгэл

Ажлын туршлага:

2007-2014 Кредит Монгол ХХК – СОЗ

2016-2020 Голомт банк – Ахлах менежер

2020-2024 Инвескор ББСБ ХК – СБТГ захирал

2025 – Кредитех СТМ ББСБ ХХК-д Аудит хариуцсан захирал



Б.Хишигтөр /ТУЗ-ийн хараат бус гишүүн/

Боловсрол:

1999-2003 МУИС – Био технологич

2008-2009 Sun Moon University – Эдийн засагч

Ажлын туршлага:

2003-2009 Анод банк – Эдийн засагч

2009-2013 Тэнгэр даатгал ХХК – Гүйцэтгэх захирал

2013-2019 Монгол даатгал ХХК – Гүйцэтгэх захирал

2019 оноос Амар даатгал ХХК – Даатгал хариуцсан захирал



Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл

Уриа үг

Ухаалаг шийдэл, Зөв хөрөнгө оруулалт

Алсын хараа

Үндэсний хэмжээнд санхүүгийн ухаалаг шийдлээрээ тэргүүлэгч, тогтвортой хөгжлийг дэмжигч, олон улсын жишигт нийцсэн банк бус санхүүгийн байгууллага болох

Эрхэм зорилго

Бид санхүүгийн зах зээлд тэргүүлэгч, иновацлаг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон харилцагч бүрийн итгэлт урт хугацааны түнш нь байх

Үнэт зүйл

Нэгдмэл байдал – Бид “Монкон Групп”-ын хамтын үнэ цэнийг илэрхийлж, салбар хоорондын уялдаа, дэмжлэгийг эрхэмлэнэ.

Тогтвортой хөгжил – Зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицож, тасралтгүй сайжруултад төвлөрнө.

Харилцагч төвтэй бодлого – Бид харилцагчийн амжилт, санхүүгийн тогтвортой байдлыг нэгдүгээрт тавьж, урт хугацааны хамтын амжилтыг эрхэмлэнэ.

Итгэлцэл ба хариуцлагатай байдал – Харилцагч болон хөрөнгө оруулагчдын итгэлийг хүндэлж санхүүгийн шийдвэр бүрийг хариуцлагатай олон талын ашигт нийцүүлсэн хамтын ажиллагааг эрхэмлэнэ.



ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тойм

ТУЗ-ийн хурлын тоо – 4

Шийдвэрийн тоо – 3

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны Засаглалын кодекст нийцүүлж, дараах шийдвэрүүдийг гарган ажиллав.

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, төсвийн гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөө, төсөв батлах тухай
- 2025 оны 2-р улирлын үйл ажиллагааны тайлан, төсвийн гүйцэтгэл
- Дотоод аудитын 2025 оны тайлан
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журмын төсөлтэй танилцах
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц бүрэлдэхүүний орон тоог хэлэлцэх тухай
- Компанийн үнэт зүйлийг шинэчлэн батлах тухай



ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо

Хараат бус ба бодит байдлыг хангах, аудитын нөөц, аудитын хамрах хүрээний хязгаарлалт, аудитын жилийн төлөвлөгөөг батлах, аудитын тайлагналын процесс, ерөнхий аудиторыг томилох, чөлөөлөх, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.



Ш.Цэрэндаваа
/Дарга/



Б.Баярчулуун
/Гишүүн/



Л.Батхуяг
/Гишүүн/



ТУЗ-ийн дэргэдэх эрсдлийн удирдлагын хороо

Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг хэлэлцэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний шийдвэр гаргах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэхэд нэгдсэн удирдлагаар хангах.



Б.Хишигтөр
/Дарга/



Г.Батбаяр
/Гишүүн/



Б.Баярчулуун
/Гишүүн/



ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Цалин урамшуулал, засаглалын хороо

Компанийн ТУЗ-ийн гишүүд, компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллыг талаар баримтлах бодлогыг баталж, хянана. ТУЗ-ийн гишүүн болон компанийн эрх бүхий албан тушаалтанд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, ТУЗ-ийн гишүүн, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид нь тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэн шалгаж, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах болон томилогдон ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүд нь шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллахад анхаарах



Б.Хишигтөр
/Дарга/



Л.Батхуяг
/Гишүүн/



Г.Батбаяр
/Гишүүн/




Компанийн засаглал

“Монголиан Файнэншл Партнерс ББСБ” ХХК нь Монгол улсад бүртгэлтэй, хязгаарлагдмал хариуцлагатай хэлбэрээр байгуулагдсан ББСБ бөгөөд Монгол улсын хууль тогтоомжоос гадна банкнаас бусад зохицуулалттай салбарын зохицуулагч Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос баталсан Компанийн засаглалын кодексийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Компанийн урт хугацааны тогтвортой хөгжилд хүрэхийн тулд бид хувь нийлүүлэгчид, харилцагчид, ажилтнууд болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалж, тэдэнтэй итгэлцэлд суурилсан хамтын ажиллагааг хөгжүүлэхийг зорьдог.



Санхүүгийн гүйцэтгэл





- 2024 оны 4 сард МҮЦАЭХ-ноос 1,8 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг гаргах зөвшөөрлийг авч 1,8 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичгийг 12 сарын хугацаатай гаргасан бөгөөд 2025 оны 4 сард амжилттай төлж дуусгасан.
- 2025 оны 4 сард МҮЦАЭХ-ноос нийт 3,8 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичиг гаргах зөвшөөрлийн дагуу 4 сард 1,462 тэрбум төгрөг, 7 сард 1 тэрбум төгрөгийн хаалттай өрийн бичгийг амжилттай гаргаж сар бүр хүүг олгон ажиллаж байна.

Компанийн соёлын арга хэмжээ ба сургалт хөгжил



Шинэ ажилтны сургалт



Спортын арга хэмжээ



Зуны зугаалга



МББСБ-ын бүх гишүүдийн хурал

Сургалтанд суусан байдал:

- Ажилтан хөгжлийн тулгуур-2025 Хүний менежмент
- Менежментийн тогтолцооны дотоод аудиторын сургалт
- Ерөнхий нягтлан бодогчийн сургалт
- Комплайнсын ажилтныг мэргэшүүлэх сургалт
- Харах өнцөг өөрчлөх

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА